

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: "Монгол Даатгал" ХК, УБГД: 9010001148, ҮЦК: MDIC, Утасны дугаар: 94001934, 1800-1990	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Даатгалын үйл ажиллагаа	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	64,132,341	
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ-ийн НБД Т.Цацрал Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Одонгэрэл	
1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Дүгнэлтийг хавсаргав	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	

3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Хохирлын харьцаа – 38.42% Зардлын харьцаа – 74,5.7%
ё	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Нийт нөөцийн сан 16,8 тэрбум төгрөг
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	“Монгол Даатгал” ХК нь зах зээлийн хувьсан өөрчлөгдөж буй орчин болон зохицуулалтын шинэ шаардлагад нийцүүлэн засаглалын бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээгээ тогтмол шинэчилж байна. Компани нь иргэд болон байгууллагуудад зориулсан 15 чиглэлийн 81 гаруй төрлийн даатгалын үйлчилгээг харилцагчдынхаа хүсэл хэрэгцээнд нийцүүлэн хамгийн өргөн сүлжээгээр хүргэж байгаа бөгөөд цаашид борлуулалтын сувгийг илүү үр ашигтай, цахим хэлбэрээр шийдэхэд анхааран ажиллаж байна. Бид Санхүүгийн зохицуулах хороотой нягт хамтран ажиллаж, ТУЗ болон түүний дэргэдэх мэргэжлийн хороодын хяналтын тогтолцоог бэхжүүлснээр эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэн ажиллаж байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Монгол даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 04/118 тоот тушаалаар баталсан НББ бодлогын баримт бичгийн дагуу бүртгэл хөтөлдөг.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	байхгүй	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	



Компанийн засаглалын бүтэц, тайлагналын тогтолцоо

Манай компанийн засаглалын бүтэц нь эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцвэрт байдал болон үр ашигтай тайлагналын тогтолцоог бүрэн хангахаар зохион байгуулагдсан байна.

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд үйл ажиллагаа, санхүүгийн хараат бус байдалд Хөндлөнгийн аудит хяналт тавьж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд тайлагнадаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдон томилогддог ба компанийн стратегийн удирдлагаар хангах, Гүйцэтгэх захирлыг томилох, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ТУЗ нь шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах зорилгоор дараах 4 хороог дэргэдээ ажиллуулдаг.

Аудитын хороо: Дотоод аудиторыг чиг үүргээр удирдаж, компанийн санхүү, дотоод хяналтын тогтолцоог хянана.

Эрсдэл даатгалын хороо: Компанийн хэмжээнд учирч болох эрсдэл, даатгалын үйл ажиллагаанд хяналт тавина.

Нэр дэвшүүлэх хороо: ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багт нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах үйл явцыг хариуцна.

Цалин, урамшууллын хороо: Удирдлагын баг, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын бодлогыг тодорхойлно.

Гүйцэтгэх удирдлага ба Түүний дэргэдэх хороод: Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах бөгөөд ТУЗ-ийн өмнө ажлаа тайлагнадаг. Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор үйл ажиллагааны чиглэлээр дагнасан Удирдлагын хороо, Нөхөн төлбөр, эрсдэлийн хороо, Бизнес хөгжлийн хороо, болон Бүтээмжийн хороодууд ажиллаж, шийдвэр гаргалтыг дэмжин ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:

№	Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	Миллиуним секюритиз	99.79 %	Байхгүй	Байхгүй
2	Бусад	0.21%		

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Тайланг хавсаргав

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Чинбатын Одонгэрэл

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Түдэвийн Цацрал

Албан тушаал: ТУЗ-ийн НБД

Гарын үсэг: